“УЛААНБААТАР ОРОН СУУЦЖУУЛАЛТ” ХХК-ИЙН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

| | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|
| 1 | Арга хэмжээ 1.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 1 зорилтын 2 арга хэмжээ 90 хувийн биелэлттэй, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн нийт 1 зорилтын 3 арга хэмжээ 90 хувь, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1 зорилтын 3 арга хэмжээ 90 хувийн биелэлттэй бөгөөд дээд газарт улирал бүр хугацаанд нь тайлагнасан. | 90 % |
| 2 | Арга хэмжээ 1.2.Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнах | Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнан ажиллаж байна. | 90% |
| 3 | Арга хэмжээ 1.3.Компанийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, байгууллагын албан хаагчдыг тогтвор суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах болон чадахуйн зарчим /мерит/-ыг тууштай хэрэгжүүлж, албан хаагчийн хандлага, ёс зүйг сайжруулах | Компанийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын албан хаагчдыг тогтвор суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах бодлогыг баримтлан чадахуйн зарчимд суурьлан ажлын гүйцэтгэл, мэдлэг ур чадварыг үнэлэн тайлант хугацаанд байгууллагын 3 албан хаагчийг тушаал дэвшүүлэн томилосон. | 90 % |
| 4 | Арга хэмжээ 1.4.Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах | Байгууллагын санхүүгийн нөөц боломжоонд тулгуурлан үйл ажиллагаанд доголдуулахгүйгээр санхүүгийн сахилга батыг сайжруулан үргүй зардлыг хэмнэн тогтоолын хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. | 90% |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | Арга хэмжээ 1.5.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78, 79 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн төсөвт байгууллагын удирдлагатай байгуулсан "Нийслэлийн Өмчийг эзэмшүүлэх гэрээ", нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагатай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ээр хүлээсэн үүргийг хангаж ажиллах | Компанийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа бөгөөд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны "Барилга байгууламж балансаас балансад шилжүүлэх тухай" 25/40 дугаартай тогтоолын хэрэгжилтийг хангаж Нийслэлийн Орон сууцны корпораци ХК-иас нийт 21,731,708,631.85 төгрөгийн бүртгэлийн үнэлгээтэй барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг хүлээн авч компанийн хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн. | 90% |
| 6 | Арга хэмжээ 1.6.Хууль, дүрмээр хүлээсэн чиг үүрэг, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээх ба Нийслэлийн Засаг даргыг шүүхийн маргаанд төлөөлж, гарсан үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн ажлын хүрээнд нийт Нийслэлийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 5 заалт 90%, Нийслэлийн Засаг даргын хуралдааны тэмдэглэл 6 заалт 70%, гүйцэтгэх захирлын Хариуцлагын гэрээний хэрэгжилт 86 хувьтай тус тус биелүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 80% |
| 7 | Арга хэмжээ 1.7.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллах | Хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангахтай холбоотой Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаал, өгсөн чиг үүргийн биелэлтийг хангах, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн өмнө байгууллагын чиг үүргийн хүрээнд шаардлагатай нөхцөлд хариуцна. | 90% |
| 8 | Арга хэмжээ 1.8.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг даргын баталсан захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4 тогтоолын 4 заалт, Нийслэлийн Засаг даргын 5 захирамжийн 10 заалтын хэрэгжилтийг 90%-тай хангаж тайлан мэдээг хугацаанд нь дээд газарт тайлагнасан. | 90% |
| 9 | Арга хэмжээ 1.9.Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, бодит үр дүнг дээшлүүлэх, тогтоосон хугацаанд тайлагнах | Компанийн дүрмээр хүлээсэн 18 чиг үүргийн хүрээнд тайлант хугацаанд хэрэгжилтийг 90%-тай хангаж ажилласан. | 90% |
| 10 | Арга хэмжээ 1.10.Алба хаагчдын сахилга хариуцлага, хандлага, ёс зүй, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулж ажил, арга хэмжээ зохион байгуулах | Албан хаагчдыг чадавхжуулах сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулж, баасан гараг бүрийн өглөөний 2 цагийг "Мэдээллийн цаг" болгон шинэ шинэлэг мэдээ , мэдээллээр санал солилцон уламжлал болгон тогтоогоод байна. Мөн байгууллагын ажилтан албан хаагчдын ур чадварыг | 90% |

| | | | |
|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор 2025 оны 25 заалт бүхий Сургалтын төлөвлөгөөг батлан төлөвлөгөөний дагуу мэргэшсэн Худалдаан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сертификат олгох сургалтад 7, Төсөвчний мэргэшүүлэх сургалтад 2, Үндэсний монгол бичгийн дүрэм эзэмших сургалтад 2 нийт 11 албан хаагчийн ур чадварыг нэмэгдүүлэн ажилласан.. | |
| 11 | Арга хэмжээ 1.11.Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх | Байгууллагын нэгдсэн цахим хуудас (www.ubos.gov.mn)-ын үндсэн агуулга загварыг сайжруулж, дэвшилтэт технологи нэвтрүүлж 2021 оны "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай" хууль, Засгийн газрын 2022 оны "Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын хүрээнд иргэд, олон нийтэд мэдээллийн хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх, мэдлэгийн сан бий болгон шинэчлэн хөгжүүлэх, кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн мэдээ мэдээллийг нийтлэх ажлыг хийж гүйцэтгэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк хуудсаар дамжуулан үйл ажиллагааг сурталчлах ажлыг тогтмол хийж байна. | 90% |
| 12 | Арга хэмжээ 1.12.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэн чиг үүргийн дагуу ажлын тайлан мэдээг гарган тайлагнан ажиллаж байна. | 90% |
| 13 | Арга хэмжээ 1.13.Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/1024 тоот захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтийг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд уялдуулах | Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтээс өөрийн байгууллагын хариуцах индексийн үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд өөрийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарал бүхий 2 индексийг байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 70% |
| 14 | Арга хэмжээ 1.14.Хотын хөгжлийн индексийн тооцох суурь, анхдагч мэдээллийн чанарыг сайжруулж, орон зайн болон шаардлагатай статистик мэдээллийг Нийслэлийн статистикийн | Хотын хөгжлийн индексийг тооцох үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах 2 индексийн дагуу Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны нийт 33 байршил дахь барилгыг буулган дахин | 70% |

| | | | |
|---|---|---|---|
| | гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, өөрийн цахим хуудас болон олон нийтэд мэдээлэх | | |
| 21 | Арга хэмжээ 1.21.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.<br>Шилэн дансны мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуулийн дагуу дараах мэдээллийг цаг хугацаанд нь оруулж баталгаажуулан ажиллахаар Сангийн яаманд байгууллагын эрх нээлгэх хүсэлтийг хүргүүлэн бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | 90% |
| 22 | Арга хэмжээ 1.22.Гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газартай зөвшилцөж, уялдуулах. | Гадаад орны ижил чиг үүргийн байгууллагын туршлага судлах зорилгоор байгууллагын гүйцэтгэх захирал болон хэлтсийн дарга 1, мэргэжилтэн 3 нар БНХАУ-ын Гуанжоу хотноо Canton Fair үзэсгэлэн яармагт оролцож байгууллагаа сурталчилсан. | 90% |
| 23 | Арга хэмжээ 1.23.Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээний талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй зөвшилцөж, мэдээллийг нэгдсэн нэг урсгалаар түгээх. | "Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-ийн цахим хуудасны үндсэн цэс, бүтэц, байрших мэдээ, мэдээллийн булан зэргийг боловсруулан батлуулав.<br>Улаанбаатар орон сууцжуулалт ХХК-ийн веб сайтыг төрийн байгууллагын веб сайтын шаардлага, стандартад нийцүүлэн хөгжүүлэх ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх байгууллага, гэрээт ажилтныг судалж танилцуулан 2025 оны 01 дүгээр сарын 28-ний өдөр тус ажлыг гүйцэтгэх ажилгантай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.<br>Веб сайтыг тогтмол хөгжүүлж, нийтлэх мэдээ, мэдээллийн төрөлжүүлэх, шинэчлэх ажил явагдаж байна. | 70% |

ТАЙЛАГНАСАН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ З.ТӨМӨРТӨМӨӨ

УЛААНБААТАР ХОТ
9025010089
7106545 СЕТ27237

“УЛААНБААТАР ОРОН СУУЦЖУУЛАЛТ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хо

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хув |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1.** Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт: НЗДҮАХ-Улаанбаатар "20 минутын хот" буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжий зохистой түвшинд хүргэх бодлого, төлөвлөлтийг боловсруулж, төвлөрлийг задлан шинээр байгуулагдах 14 хот, 42 нэгж хорооллыг хөгжүүл иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ:1.1. НЗДҮАХ-1.2.6, НХТЖҮЧ-9.2.2 Толгойт дэд төвийг орон сууцжуулах төслийг эхлүүлнэ. | - | Хэрэгжүүлэх төслийн тоо | - | 100% | Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/93 дугаар "Гэр хорооллыг орон сууцжуулах талаар авах арга хэмжээний тухай" захирамжаар Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 34 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Толгойт дэд төв орчмын 133.3 га талбайд гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгчээр ажиллахыг манай байгууллагад даалгасан. Толгойт дэд төв орчмын гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, ГАДИП төслийн нэгжтэй хамтран байршил, нэгж талбарын судалгааг хийхэд шаардлагатай программ хангамж, дата мэдээллийн баазыг ашиглах талаар хүсэлтийг гаргаж, барилгажих талбайн бэлтгэл ажлыг хангаж байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Арга хэмжээ:1.2. НЗДҮАХ-1.2.13, НХТЖҮЧ-9.8.1 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах төслийг эхлүүлнэ. | - | Буулгасан барилга, эхлүүлсэн төслийн тоо | - | 100% | Нийслэлийн Засаг даргын 9 удаагийн Захирамжаар 35 байршил дээр төсөл хэрэгжүүлэх эрх шилжин ирсэн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгуудын газрын кадастрын зураг хийлгэж байгууллагын нэр дээр бүртгэлжүүлэхээр кадастрын хэмжилт хийлгэн, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 7 удаагийн албан бичгээр 12 байршлыг баталгаажуулж өгөх хүсэлт илгээсэн байна. | 90% |
| **Зорилт 2.** Хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулан гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мөн хот дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу хэрэгжүүлэхээр даалгасан, түүний нөлөөлөлд өртсөн эзэмшигч, өмчлөгч этгээдийг ту суурьшуулах орон сууцаар хангах, нөхөх олговрын асуудлыг шийдвэрлэж, нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах, хот байгуулалт, барилгын хөгжилд бодитой хувь нэмэр оруулах. | | | | | | | |
| 3 | Арга хэмжээ:2.1. Хот дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу хэрэгжүүлэхээр даалгасан гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх. | - | Дахин төлөвлөлтөд хамруулах гэр хорооллын өрхийн судалгаа | - | 35 | Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөлд хамрагдсан 35 байршлын оршин суугчдын 1234 иргэдийн уулзалтыг 53 удаа тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргаатай хамтран зохион байгуулан мэдээлэл өгч ажилласан. | 100% |
| 4 | Арга хэмжээ:2.2. Орон сууцжуулах үйл ажиллагааны хүрээнд гүйцэтгэгч этгээдийг нээлттэй сонгон шалгаруулах, холбогдох гэрээ | - | Сонгон шалгаруулалтын үр дүн хувиар | - | | 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах СТ-4 дүгээр байр СХД-01, Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 22 дугаар байр СБД-01, Чингэлтэй дүүргийн 6 дугаар | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих. | | | | | хорооны нутаг дэвсгэрт байрлах 44 дүгээр байр ЧД-01, 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 6 дугаар байр ЧД-02, Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 5 дугаар байр БЗД-01, 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Баянгол дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 32 дугаар байр БГД-01, 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 35, 36 дугаар байр БГД-02, Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 33 дугаар байр СХД-02 зэрэг нийт 8 байршилд сонгон шалгаруулалт зарлан Үнэлгээний хорооны үнэлгээ өртгөж байна. | |
| 5 | Арга хэмжээ:2.3. Орон сууцжуулах үйл ажиллагааны хүрээнд холбогдох үйл ажиллагааны зардал, хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах. | - | Мөнгөн хөрөнгө болон орлого төвлөрүүлэх | - | 100% | 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс НОСК-иас шилжин ирсэн 4 байршлын орлогыг төвлөрүүлж холбогдох үйл ажиллагааны зардлыг захиран зарцуулж байна. | 100% |
| 6 | Арга хэмжээ:2.4. Орон сууцжуулах үйл ажиллагааны хүрээнд төсөл, төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчтэй харилцан тохиролцож гэрээ байгуулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, | - | Гэрээний хэрэгжилтийн хувь | - | 100% | Түр суурьшуулах орон сууцанд хамрагдсан Сүхбаатар дүүргийн 11 хорооны 813, 814 дүгээр байрны 306, Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хорооны 50 айлын орон сууцны 50, Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны Сэлбэ 50 айлын орон сууцны 50 оршин суугч иргэдтэй түр оршин суух түрээсийн гэрээг 2025 онд шинээр байгуулах зорилгоор 153 мэдэгдэх хуудсыг тарааж, 51 иргэдтэй биечлэн уулзаж гэрээний биелэлтийг | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гэрээний биелэлтийг хамтран дүгнэх. | | | | | дүгнэсэн байна. Нийт түрээсийн 406 айл өрхтэй гэрээ байгуулсан. | |
| 7 | Арга хэмжээ:2.5. Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд хот байгуулалтын холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагаар батлуулах. | - | Батлуулсан баримт бичгийн тоо, хэрэгжилт хувиар | - | 100% | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 107 дугаар "Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагаа хэрэгжүүлэх байршил тогтоох тухай" тогтоолоор Сүхбаатар дүүгийн 12, 13 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 11, 12, 13, 14, 15, 16, 18, 22 дугаар хорооны нутаг дэвсгэр, Сэлбэ дэд төв орчмын 2 дугаар ээлжийн 733 га талбай, Сүхбаатар дүүргийн 15, 17 дугаар хорооны нутаг дэвсгэр, Дамбадаржаа дэд төв орчмын 71.8 га талбай, Сонгинохайрхайн дүүргийн 1, 2, 34 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Толгойт дэд төв орчмын 133.3 га талбайг орон сууцжуулах байршлыг тогтоолгосон. | 90% |
| 8 | Арга хэмжээ:2.6. Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан барилгажилтын төслийн дагуу орон сууцжуулах үйл ажиллагаанд захиалагчийн хяналт тавих. | - | Төслийн хэрэгжилтийн хувиар | - | 100% | Сонгинохайрхан дүүрэгт 11, Чингэлтэй дүүрэгт 2, Сүхбаатар дүүрэгт 2, Баянзүрх дүүрэгт 1, Баянгол дүүрэгт 19 байршлын ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны байрыг буулган дахин барилгажуулах төслийг хэрэгжүүлэх эрх олгогдсон. Мөн Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/93 дугаар захирамжаар Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 34 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Толгойт дэд төв орчмын 133.3 га талбайд гэр хорооллыг орон | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суурьшуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг даалгасан. Дээрх ажлуудын хүрээнд Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны 21, 22 дугаар байр, Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны СТ-4 дүгээр байрууд нь архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлагдсан байх бөгөөд бусад төслүүдийн хувьд одоогоор зураг төсөл батлагдаагүй, төсвийн төсөөлөл, тооцоо судалгаа хийгдэх шатандаа байна. | |
| 9 | Арга хэмжээ:2.7. Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулан гэр хорооллыг орон сууцжуулах нэгж талбарыг сонгон батлуулах санал хүргүүлэх. | - | Саналын тоо, хэрэгжилтийн хувь | - | 100% | Толгойт дэд төв орчмын гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай хамтран байршил, нэгж талбарын судалгааг хийхэд шаардлагатай программ хангамж, дата мэдээллийн баазыг ашиглах талаар санал хүсэлтийг гаргаж, барилгажих талбай, нэгж талбарын судалгааг хийж байна. | 90% |
| **Зорилт 3.** Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: Хууль тогтоомж, Засгийн газрын болон харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангаж ажиллана. . | | | | | | | |
| 10 | Арга хэмжээ:3.1. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | | | | | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 1 зорилтын 2 арга хэмжээ 50 хувийн биелэлттэй, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн нийт 1 зорилтын 3 арга хэмжээ 70 хувь, Нийслэлийн хөгжлийн 2025 оны | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хангаж дээд газарт тайлагнах. | | | | | төлөвлөгөөний 1 зорилтын 3 арга хэмжээ 70 хувийн биелэлттэй бөгөөд дээд газарт улирал бүр хугацаанд нь тайлагнасан. | |
| 11 | Арга хэмжээ:3.2. Засаг даргатай байгуулсан "Хариуцлагын гэрээ", байгууллагын үйл ажиллагааны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг нэгтгэн хагас, бүтэн жилээр дээд газарт тайлагнах. | - | Хэрэгжилтийн хувиар | - | 100% | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас "Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-ийн удирдлагатай байгуулах хариуцлагын гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр 01/109 тоот гэрээгээр байгуулсан. Байгууллагын үйл ажилллагааны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг мөн батлуулж, төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг 85%-ийн гүйцэтгэлтэй Нийслэлийн Засаг даргын Тамгийн газарт хүргүүлэн ажилласан. | 85% |
| 12 | Арга хэмжээ:3.3. Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулна, | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100% | Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг байгуулан бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | 70% |
| 13 | Арга хэмжээ:3.4. Хариуцсан чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | | Мангай байгууллага нь 20205 онд шинээр байгуулагдсан бөгөөд байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийх, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлэх, удирдлагын тогтолцоонд шинэчлэл өөрчлөлт хийх асуудлаар удирлагын түвшинд хэлэлцэн холбогдох дээд шатны байгууллагуудтай хамтран ажиллаж байна./ | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | Арга хэмжээ:3.5. MNS ISO 9001:2016 - чанарын менежментийн тогтолцооны стандартын нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. стандартын баталгаажуулалтыг эрх бүхий байгууллагаар хийлгэнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | | MNS ISO 9001:2016 - чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх ажлын бэлтгэл ажлыг хангаж стандартын баталгаажуулалтыг хийлгэх байгууллагын сонгон шалгаруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. | 70% |
| 15 | Арга хэмжээ:3.6. Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. | - | Бэлтгэл ажил хангах | - | | Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах сайжруулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2025 оны 04 дүгээр сарын А/21 дүгээр тушаалаар Хяналт үнэлгээний ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. | 80% |
| 16 | Арга хэмжээ:3.7. Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ. | - | Боловсруулсан мэдээллийн тоо | - | 2 | Тус арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, ГАДИП төслийн нэгж, Дүүргүүд, Хороодтой хамтран статистикийн мэдээллийг боловсруулан, холбогдох газарт тайлагнан ажиллаж байна. | 100% |
| 17 | Арга хэмжээ:3.8. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 90-ээс дээш хувьтай хэрэгжсэн байх | Монгол Улсын Засгийн газрын 2011 оны "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж байгууллагын 8 хэлтэс 1 албаны дотоод үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг зохион байгуулан холбогдох зөвлөмж, мэдээллийг өгч ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | Арга хэмжээ:3.9. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, 2025 оны эдийн засгийн үзүүлэлтийг хангаан үр ашгийг нэмэгдүүлнэ. | - | Эдийн засгийн үр ашгийн нэмэгдүүлж, хэмнэсэн мөнгөн хөрөнгийн дүн төгрөгөөр | | 100% | Байгууллагын санхүүгийн нөөц бололцоонд тулгуурлан ү<br><br>йл ажиллагаанд доголдуулахгүйгээр санхүүгийн сахилга батыг сайжруулан зардлыг хэмнэн тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 90% |
| 21 | Арга хэмжээ:3.10. Шилэн дансны хуулийн хэрэгжилийг хангах холбогдох гүйлгээ, тайлан мэдээ, тушаал шийдвэрийг стандарт, журмын дагуу шилэн дансны цахим хуудсанд байршуулж тайлагнах | | Шилэн дансны хуулийн дагуу байршуулсан тоо | - | 100% | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.<br>Шилэн дансны мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуулийн дагуу дараах мэдээллийг цаг хугацаанд нь оруулж баталгаажуулан ажиллахаар Сангийн яаманд байгууллагын эрх нээлгэх хүсэлтийг хүргүүлэн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 90% |
| 22 | Арга хэмжээ:3.11. Албан хэрэг хөтлөлтийн систем erp.ulaanbaatar.mn системийн edoc цэсэд бүртгэгдсэн албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн байдалд хяналт тавьж ажиллах, баримт бичгийн эргэлтийн мэдээ, өргөдөл гомдлын тайланг | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь, тоо | - | 100% | Албан хэрэг хөтлөлтийн систем Edoc программд бүртгэгдсэн холбогдох албан бичиг, өргөдлийг журмын дагуу хөтөлж хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллаж байна.<br>Тайлант хугацаанд явуулсан бичиг нийт 146 хариугүй бичиг 136 хариутай бичиг 10, ирсэн бичиг нийт 102 бөгөөд хариутай 7, хариугүй 95 нийт хуудасны хүлээн авч шийдвэрлэсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сар тутамд гаргаж удирдлагуудад танилцуулах. | | | | | Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 1,8 хоногтой байна. | |
| 23 | Арга хэмжээ:3.12. "Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" MNS6395:2022 стандартын дагуу хэвлэмэл хуудсыг захиалах, албан хэргийг крилл болон үндэсний хос бичгээр хөтлөж, албан хаагчдын Монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлнэ. | Дотоод эх үүсвэр | Хэрэгжилтийн хувь | - | 100% | MNS6395:2022 стандартын дагуу байгууллагын хэвлэмэл хуудсыг захиалж албан хэрэгцээнд ашиглаж байна.<br>Албан хэргийг крилл болон үндэсний хос бичгээр хөтлөж, явсан бичгийн стандартыг ханган албан хаагчдын Монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. | 100% |
| 24 | Арга хэмжээ:3.13. "Албан хаагчдыг хөгжүүлэх, сургах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах. | - | Хамрагдсан албан хаагчид | - | Албан хаагчийг тэтгэлэгт хамруулсан тоо. | Нийгмийн баталгааг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тайлант хугацаанд байгууллага нь албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, тэдний нийгмийн хамгааллыг дэмжих зорилгоор байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу нийт 4 албан хаагчид нийт 1,600,000 төгрөгийн санхүүгийн буцалтгүй дэмжлэг үзүүлсэн байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | Арга хэмжээ:3.14. Ажилтан, албан хаагчдыг богино болон дунд хугацааны, мэргэшүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулах, мэргэжил ур чадварыг дээшлүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах. | - | Сургалтад хамрагдах албан хаагчдын тоо | - | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо зарцуулсан төсөв. | Байгууллагын ажилтан албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор 2025 оны 25 заалт бүхий Сургалтын төлөвлөгөөг батлан төлөвлөгөөний дагуу мэргэшсэн Худалдаан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сертификат олгох сургалтад 7, Төсөвчний мэргэшүүлэх сургалтад 2, Үндэсний монгол бичгийн дүрэм эзэмших сургалтад 2 нийт 11 албан хаагчийн ур чадварыг нэмэгдүүлэн ажилласан.<br>Гадаад орны ижил чиг үүргийн байгууллагын туршлага судлах зорилгоор байгууллагын гүйцэтгэх захирал болон хэлтсийн дарга 1, мэргэжилтэн 3 нар БНХАУ-ын Гуанжоу хотноо Canton Fair үзэсгэлэн яармагт оролцож байгууллагаа сурталчилсан. | 100% |
| 26 | Арга хэмжээ:3.15. Ажилтан, албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах. | Дотоод эх үүсвэр | Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан тоо, хувь | - | 100% | Байгууллагын бүтэц, орон тооны бүрдэлт тайлант хугацаанд дутуу байсан тул ажилтан, албан хаагчдыг үзлэг, сургалтад хамруулах нөхцөл бүрдээгүй.<br>Холбогдох эмнэлэг, байгууллагуудтай хамтын ажиллагааг эхлүүлсэн бөгөөд хуваарь гаргах шатанд явж байна. | 90% |
| 27 | Арга хэмжээ:3.16. "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2024- | - | Хэрэгжилтийн хувь | - | 100% | Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-ны авилгын эсрэг үйл ажиллагааны | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2030 он" хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | | | 2025 онд хэрэгжүүлэх 3 зорилт 22 бүлэгт төлөвлөгөөг гарган байгууллагын даргаар харьяа, хэлтэс, алба, ажилтан, албан хаагчдад хүргэсэн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | |
| 28 | Арга хэмжээ:3.17. "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он" хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Хэрэгжилтийн хувь | - | 100% | Байгууллагын ажилтан албан хаагч нарт Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он" хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төрийн алба хаагчийн ёс зүйг эрхэмлэн хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн иргэнтэй зөв боловсон харьцах, байгууллагын дотоод журмыг дагаж мөрдөхөд мэргэжил арга зүйгээр хангаж ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 80% |
| 29 | Арга хэмжээ:3.18. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 тоот захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтийг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд уялдуулах | | Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг нураан дахин барилгажуулах-Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны хэлтэс; | | | Хотын хөгжлийн индексийг тооцох үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах 2 индексийн дагуу Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны нийт 33 байршил дахь барилгыг буулган дахин барилгажуулах ажлын зураг төслийг боловсруулах, барилгын ажлын бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4.** Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт: Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны нээлттэ ил тод байдлыг хангаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | | | | | | | |
| 30 | Арга хэмжээ:4.1. Иргэд, хуулийн этгээдээс байгууллагын албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг бүх талаас нь нягталж судлан, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж хариу өгөх ажлыг шуурхай зохион байгуулах арга хэмжээ авч ажиллах. | - | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо | - | Шийдвэрлэлтийн дундаж хугацаа | Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас удирдлага болон албан хаагчдад тайлангт хугацаанд нийт 9 өргөдөл гомдол санал, хүсэлт ирсний 8 нь шийдвэрлэгдсэн бөгөөд 1 өргөдөл судлагдаж байгаа болно. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 12 хоног 21 цаг 36 минут байна. | 85% |
| 31 | Арга хэмжээ:4.2. Байгууллагын цахим хуудсыг төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, аюулгүй байдлыг хангаж, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан зохион байгуулах. | Дотоод эх үүсвэр | Хэрэгжилтийн хувь | - | 100% | “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-ийн цахим хуудасны үндсэн цэс, бүтэц, байрших мэдээ, мэдээллийн булан зэргийг боловсруулан батлуулав.<br>Улаанбаатар орон сууцжуулалт ХХК-ийн веб сайтыг төрийн байгууллагын веб сайтын шаардлага, стандартад нийцүүлэн хөгжүүлэх ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх байгууллага, гэрээт ажилтныг судалж танилцуулан 2025 оны 01 дүгээр сарын 28-ний өдөр тус ажлыг гүйцэтгэх ажилтантай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.<br>Веб сайтыг тогтмол хөгжүүлж, нийтлэх мэдээ, мэдээллийн төрөлжүүлэх, шинэчлэх ажил явагдаж байна. | 100% |
| 32 | Арга хэмжээ:4.3. Иргэд, олон нийтэд | - | Иргэд бодит мэдээллээр | - | 100% | “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын чиг үүрэг, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг танилцуулж мэдээ мэдээллээр хангах | | хангагдсан байх | | | ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууц, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөлтэй холбоотой фото, видео мэдээ бэлтгэн байгууллагын албан цахим хуудсуудад тогтмол нийтэлж байна.<br>Мөн Нийслэлийн засаг даргын захирамжуудыг үндэслэн ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг дахин төлөвлөж барилгажуулах компани сонгон шалгаруулах зар боловсруулан байгууллагын албан цахим хуудсуудад байршуулж байна. | |
| **Зорилт 5.** Бусад чиг үүргийн хүрээнд | | | | | | | |
| 33 | Арга хэмжээ:5.1 Монгол улсын ерөнхийлөгчий зарлигийн дагуу Үндэсний мод тарих өдрийг тохиолдуулан бүх нийтээр мод тарих, цаашид арилан хамгаалах ажлыг зохион байгуулах. | Дотоод эх үүсвэр | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 1 | Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Үндэсний мод тарих өдрийг тохиолдуулан бүх нийтээр мод тарих, цаашид арчлан хамгаалах ажлыг 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд байрлах Инчоны цэцэрлэгт хүрээлэнд зохион байгууланнийт 60 хуайсны суулгац тарьж бүх хэлтэс, албадын ажилчдыг хамруулсан ажилласан. | 100% |
| 34 | Арга хэмжээ:5.2. Байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд биеийн тамир, соёл урлагийн уралдаан тэмцээнийг зохион байгуулах, дээд газар болон байгууллагаас | Дотоод эх үүсвэр | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 | 5 | Олон нийтийн арга хэмжээнд:<br>-"Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-ийн ажилтан, алба хаагчид өнөөдөр 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр бүх нийтийн их цэвэрлэгээнд нэгдэж, Хуримын ордны урд талаас Хүүхдийн ордны баруун талын уулзвар хүртэлх 500 м2 зам | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд хамруулан ажиллах. | | | | | зам талбайг цэвэрлэн 515 кг хатуу хог хаягдлыг шуудайлан ачуулсан.<br>-Улаанбаатар хотноо 10 дахь жилдээ зохион байгуулж буй уг марафонд байгууллагын нийт 33 албан хаагч 5 км-ийн замд гүйж амжилттай оролцсон.<br>-2025.05.31-нд Улаанбаатар орон сууцжуулалт ХХК-иас зохион байгуулсан хүүхдийн баярын арга хэмжээнд 3 байршлийн түр суурьшуулах орон сууцуудын 500 гаруй хүүхэд оролцож бэлэг авч, урлагийн үзүүлбэр үзэн үлгэрийн баатруудтай зураг татуулж сэтгэл дүүрэн нэгэн өдрийг хамтдаа өнгөрүүллээ. | |

**Хэрэгжилтийн дундаж хувь: 86%**

УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ОРОН СУУЦЖУУЛАЛТ ХХК
9026010089
7106545 СЕТ27237

ТАНИЛЦСАН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ З.ТӨМӨРТӨӨМӨӨ

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА Ж.БАЛЖИННЯМ

БОЛОВСРУУЛСАН:
ДЭЭД ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭР, ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.УНДРАХ

## “УЛААНБААТАР ОРОН СУУЦЖУУЛАЛТ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 06 дугаар сарын 05 Улаанбаатар хот

### <u>БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН</u>

**Тусгагдсан зорилт 1.**

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт: Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр-Улаанбаатар "20 минутын хот" буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлого, төлөвлөлтийг боловсруулж, төвлөрлийг задлан шинээр байгуулагдах 14 хот, 42 нэгж хорооллыг хөгжүүлж иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

**ЗОРИЛТ 1.1.** Эрх бүхий дээд байгууллагын хууль эрх зүйн бодлогын баримт бичгийн хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/93 дугаар “Гэр хорооллыг орон сууцжуулах талаар авах арга хэмжээний тухай” захирамжаар Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 34 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Толгойт дэд төв орчмын 133.3 га талбайд гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгчээр ажиллахыг “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-д даалгасан.

Зураг№01






Уг захирамжийн хүрээнд Толгойт дэд төв орчмын гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Гадип төслийн нэгжтэй хамтран байршил, нэгж талбарын судалгааг хийхэд шаардлагатай программ хангамж, дата мэдээллийн баазыг ашиглах талаар хүсэлтийг гаргаж, барилгажих талбайн судалгаа хийгдэж байна.

Зураг№02




**Хүрсэн үр дүн**: Тайлант хугацаанд Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн төслийн нэгж "Гадип"-аас дараах баримт бичгийг хүлээлцэх акт үйлдэн хүлээн авч ажиллав. Үүнд:

- 23 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураглал
- 23 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тайлан Боть-1
- 23 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний одоогийн байдлын судалгааны тайлан Боть-1
- 23 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлтийн тайлбар бичиг Боть-1
- Толгойт дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн трасс, ариутгах татуургын шугамын трасс, дулааны шугамын трасс, мэдээлэл холбооны шугамын трасс, цахилгааны кабель шугамын трасс, авто замын ажлын трасс, батлагдсан ажлын зураг төсөл

## ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

**ЗОРИЛТ 2.1.** Хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 107 дугаар "Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагаа хэрэгжүүлэх байршил тогтоох тухай" тогтоолоор Сүхбаатар дүүгийн 12, 13 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 11, 12, 13, 14, 15, 16, 18, 22 дугаар хорооны нутаг дэвсгэр, Сэлбэ дэд төв орчмын 2 дугаар ээлжийн 733 га талбай, Сүхбаатар дүүргийн 15, 17 дугаар хорооны нутаг дэвсгэр, Дамбадаржаа дэд төв орчмын 71.8 га талбай, Сонгинохайрхайн дүүргийн 1, 2, 34 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Толгойт дэд төв орчмын 133.3 га талбайг орон сууцжуулах байршлыг тогтоосон. Тус ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/93 дугаар "Гэр хорооллыг орон сууцжуулах талаар авах арга хэмжээний тухай" захирамжаар Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 34 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Толгойт дэд төв

орчмын 133.3 га талбайд гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгчээр ажиллахыг “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-д даалгасан.

Зураг№03




Тус ажлын хүрээнд Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай хамтран байршил, нэгж талбарын судалгааг хийхэд шаардлагатай программ хангамж, дата мэдээллийн баазыг ашиглах талаар хүсэлтийг гаргаж, барилгажих талбайн судалгааны ажил хийгдэж байна.

Зураг№04




Хэрэгжилт хувь 100 хувьтай.

**ЗОРИЛТ 2.2**. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулах ажлын хүрээнд тус төлөвлөгөөнд санал тусгуулахаар бэлтгэн ажиллаж байна.

Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх чиг үүргийн дагуу Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Гадип төслийн нэгж, Дүүргүүд,

Хороодтой хамтран статистикийн мэдээллийг боловсруулан, холбогдох газарт тайлагнан ажиллаж байна.

Зураг№05



**Зорилт 3.1** Бусад чиг үүргийн хүрээнд:

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулган дахин барилгажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хэлтсийн нийт мэргэжилтнүүд Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хуваарилагдан ажил үргэлжилж байна. Тухайлбал:

1. Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны хүрээнд 5 байршлын 19 орон сууцны барилгыг дахин барилгажуулах ажлын эрх шилжин ирсэн байна.

Зураг№06



Тус ажлын хүрээнд Баянгол дүүргийн 2 дугаар хорооны 1, 2, 3, 5, 6 , 7, 28, 29, 30 дугаар байр, 3 дугаар хорооны 35, 36 дугаар байрны сууц өмчлөгч иргэдтэй болон Хорооны ажлын албатай хамтарсан уулзалтыг зохион байгуулж, Хяналтын хороог байгуулах, төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороонд иргэдийг төлөөлөх төлөөллийг тодорхой болгох талаарх мэдээллийг өгч, заавар зөвлөмжийг өгч ажиллалаа. Мөн дээрх дурдсан байршлууд болон тус дүүргийн 20 дугаар хорооны БХ1-27, БХ2-27, БХН-30, БХН-48, ттэ-37, ОС-8, АТ-12 байрнуудын үзүүлэн, танилцуулга мэдээллийг бэлтгэж ажилласан.

ЗурагNº07





Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аж ахуй нэгж, иргэдээс ирүүлсэн хүсэлтийг тухай бүр судалж, иргэдийг хүлээн авч уулзаж, мэдээ мэдээллээр хангаж ажиллав.

ЗурагNº08





2. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/358 дугаар захирамжаар манай байгууллагад шилжин ирсэн Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 1-48, 2-48, 4-48 дугаар орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны хүрээнд тус байрнуудын иргэд, оршин суугчидтай 3 удаагийн уулзалтыг зохион байгуулан саналын хуудас холбогдох материалыг 100 хувьтайгаар бүрдүүлэн Нийслэлийн Орон сууцны газарт хүргүүлж ажиллав.

ЗурагNº09









3. Мөн өдрийн А/359 дүгээр захирамжийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай СТ-4 дүгээр орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны хүрээнд буулгалтыг 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 30-ны өдрүүдэд Дүүргийн Засаг даргын Тамгын газраас "Танан цамхаг консалтинг" ХХК-иар нураалтын ажлыг хариуцуулан буулгасан. Тухайн төслийн ажлын аж ахуй нэгжийн сонгон шалгаруулалтын ажил үргэлжилж байна.

Зураг№10





Зураг№11





Мөн 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хорооны ХМК 1, 2, 3, 4, 5, 6 дугаар байрны 155 оршин суугч, өмчлөгчдийн саналын хуудсыг холбогдох материалын хамт Нийслэлийн Орон сууцны бодлогын газарт хүргүүлж ажиллав. Ажлын явц 50 хувьтай.

Зураг№12





4. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/636 дугаар захирамжаар манай байгууллагад шилжин ирсэн ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр тус байрны өмчлөгч иргэд, Баянзүрх дүүргийн 19 дугаар хороо, "Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-ийн төлөөллүүдийн хамтарсан уулзалтыг зохион байгуулж 38 иргэд оролцон 79,2 хувийн ирцтэй хамрагдав. Мөн тус байрны 48 айл өрхийн 100 хувийн саналтайгаар сонгон шалгаруулалт зарлагдан ажил үргэлжилж байна.

Зураг№13











**Зорилт 4.** Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт: Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:4.1.**Дахин төлөвлөлтөд орсон ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууц, гэр хороолол болон түр суурьшуулах орон сууцны оршин суугчдыг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах

**Хүрсэн үр дүн:** Дахин төлөвлөлтийн төсөлд хамрагдсан нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчид мөн мэргэжлийн хяналтын байгууллагаас ашиглалтын шаардлага хангахгүй барилгын дүгнэлт гаргуулж Нийслэлийн Засаг даргын тамгын газраас тус барилгыг дахин төлөвлөлтөд оруулах захирамж хүлээж буй оршин суугчдад зориулсан дахин төлөвлөлтийн үе шат, хуулийн зохицуулалт, иргэдийн оролцоо, "Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-ийн чиг үүрэг, үйл ажиллагаа зэрэг асуудлаар мэдээлэл өгөх төлөвлөгөөт уулзалтуудад оролцож, мэдээ бэлтгэн цахим орчинд түгээж шаардлагатай мэдээллээр хангаж байна.






ХЯНАЛТЫН ХОРОО ГЭЖ ЮУ ВЭ? Нэг айлын ч гэсэн амьдрах орчныг сайжруулахын төлөө явж байгаа гэдгийг ухамсарлаж оршин суугчи...



Улаанбаатар орон сууцжуулалт ХХК's Post

Улаанбаатар орон сууцжуулалт ХХК
June 5 at 9:38 AM

БГД-ИЙН 3-Р ХОРООНЫ 35, 36-Р БАЙРНЫ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН АСУУДЛААР НЭЭЛТТЭЙ УУЛЗАЛТ БОЛЛОО

БГД-ийн 3-р хорооны 35, 36 дугаар байрны сууц өмчлөгч нартай “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-ийн Захиргаа, санхүүгийн газар, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны хэлтсийн мэргэжилтнүүд уулзлаа.

35, 36 дугаар байрны нийт сууц өмчлөгчдийн тоо 63 бөгөөд өмнөх төсөл хэрэгжүүлэгчдийн хариуцлагагүй үйлдлээс үүдэн иргэдийн итгэл алдарч, сэтгэл дундуур байгааг илэрхийлэв.

Байгууллагын зүгээс тус байршлын дахин төлөвлөлтийн төслийг цаашид амжилттай үргэлжлүүлэх арга замын тухай нээлттэй хэлэлцэж, сууц өмчлөгчдийн санал гомдлыг сонслоо.

Түр суурьшуулах байрны оршин суугчдад тус иргэдийг хамарсан байгууллагын арга хэмжээ, шуурхай мэдээллийг тогтмол хүргэж байна.

Хэрэгжилт хувь – 100%

**Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт: Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** Улаанбаатар орон сууцжуулалт ХХК-ийн 2025 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөний арга хэмжээ 4.2. Байгууллагын цахим хуудсыг төрийн байгууллагын веб сайтад тавих шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, аюулгүй байдлыг хангаж, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан зохион байгуулах.

**Хүрсэн үр дүн:**

- “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-ийн цахим хуудасны үндсэн цэс, бүтэц, байрших мэдээ, мэдээллийн булан зэргийг боловсруулан батлуулав.
- Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-ийн веб сайтыг төрийн байгууллагын веб сайтын шаардлага, стандартад нийцүүлэн хөгжүүлэх ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх байгууллага, гэрээт ажилтныг судалж танилцуулав.
- 2025 оны 01 дүгээр сарын 28-ний өдөр тус ажлыг гүйцэтгэх ажилтантай ажил гүйцэтгэх гэрээ боловсруулан батлуулав.

Веб сайтыг тогтмол хөгжүүлж, нийтлэх мэдээ, мэдээллийн төрөлжүүлэх, шинэчлэх ажил явагдаж байна.




Хэрэгжилт хувь – 100%

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** Улаанбаатар орон сууцжуулалт ХХК-ийн 2025 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөний арга хэмжээ 4.1. Иргэд, олон нийтэд байгууллагын чиг үүрэг, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг танилцуулж мэдээ мэдээллээр хангах

**Хүрсэн үр дүн:** “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууц, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөлтэй холбоотой фото, видео мэдээ бэлтгэн байгууллагын албан цахим хуудсуудад тогтмол нийтэлж байна.

Мөн Нийслэлийн засаг даргын захирамжуудыг үндэслэн ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг дахин төлөвлөж барилгажуулах компани сонгон шалгаруулах зар боловсруулан байгууллагын албан цахим хуудсуудад байршуул байна.




Хэрэгжилт хувь – 100%

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:1.3.**Хот суурин газрын дахин төлөвлөлт, хотын менежмент, ашиглалтын шаардлага хангахгүй барилгын сэргээн засварлалт зэрэгтэй холбоотой олон улсын жишиг стандарт, амжилттай хэрэгжүүлсэн төслүүдийн талаарх гадаад мэдээ бэлтгэж нийтлэх

**Хүрсэн үр дүн**: Байгууллагын албан ёсны вэбсайт, фэйсбүүк хуудаст нийтэлсэн фото мэдээ – 3

1. "Түүхийн дурсгалт барилгыг дахин төлөвлөхийн ач тус"
2. "15 минутын хот" концепц дөрөвхөн жилийн дотор Парисыг өөрчилжээ"
3. Сөүл хотын Чонгичон (cheonggyecheon) горхи: дахин төлөвлөлтийн жишиг
4. "АНУ-ын Детройт хотын Book tower-ийн сэргээн засварлалтын сонирхолтой баримтуудаас..."

Хэрэгжилт хувь – 30%

**Тусгагдсан Зорилт 2. "Улаанбаатар орон сууцжууллалт" ХХК-ийн цахим орчин дахь орон зай, нөлөөллийг нэмэгдүүлэх**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: 2.1.** Байгууллагын Цахим хуудаснуудад нийтэлсэн мэдээ, мэдээллийн олон нийтэд хүрэх цар хүрээг тэлж цахим хуудаснуудын дагагчийн тоог нэмэгдүүлэх

**Хүрсэн үр дүн:** Байгууллагын албан ёсны цахим хуудсуудын дагагчийн тоо:

- Фэйсбүүк - **15,826**




Нийтэлсэн мэдээ, мэдээллийн олон нийтэд хүрэх цар хүрээг тэлж цахим хуудсуудын дагагчийн тоог нэмэгдүүлэх зорилгоор төсөв (Boost) боловсруулж байна.

Хэрэгжилт хувь – 50%

**Тусгагдсан Зорилт 3. "Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-ийн үйл ажиллагааг сурталчлах контент бэлтгэх**

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: 3.1.**Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэл, хот байгуулалт, дахин төлөвлөлттэй холбоотой мэдлэг олгох зорилгоор цуврал подкаст хийх төлөвлөгөө боловсруулан батлуулах, төлөвлөгөөний хэрэгжилт хангах

**Хүрсэн үр дүн:** Цуврал подкаст бэлтгэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Подкастын агуулгын ерөнхий концепц, бүтэц, чиглэлийг тодорхойлсон анхан шатны төлөвлөгөө боловсруулж байна.
- Подкастад оролцох, хамтран ажиллах мэргэжилтэн, зочдын анхан шатны судалгаа хийж байна.
- Подкастын техник хэрэгсэл, бичлэг хийх студи, подкаст байршуулах цахим платформуудын судалгаа хийж байна.
-



Хэрэгжилт хувь – 90%

**Зорилт 5.** Бусад чиг үүргийн хүрээнд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Үндэсний мод тарих өдрийг тохиолдуулан бүх нийтээр мод тарих, цаашид арчлан хамгаалах ажлыг зохион байгуулах аяны хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр "Инчоны цэцэрлэгт хүрээлэн" төгөлд байгууллагын ажилтан, албан хаагчдын хамт 60 ширхэг мод тарьж үйл ажиллагаанд оролцлоо.

Зураг№14



Тайлант хугацаанд долоо хоног бүрийн уламжлалт Баасан гарагт зохион байгуулагддаг "Мэдээллийн цаг" арга хэмжээнд хэлтсийн мэргэжилтнүүд тухай бүрт хамрагдсан.

Зураг№15



ТАНИЛЦСАН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ З.ТӨМӨРТӨӨМӨӨ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ГАЗРЫН ДАРГА Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА Ж.БАЛЖИННЯМ

БОЛОВСРУУЛСАН:
ДЭЭД ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭР, ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.УНДРАХ